

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/8/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Аудитор: Э.Эрдэнэбат

Утас: 99352099

Цахим хаяг: [munguntsetsegz@audit.gov.mn](mailto:munguntsetsegz@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4.5.1 Завсрын аудитын талаар .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	14
5.1 Төлбөрийн акт .....	14
5.2 Албан шаардлага .....	14
5.3 Зөвлөмж .....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Н.ГАНБААТАР ТАНАА

2025.02.25 № 117

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд “Шинэ хоршоо хөдөлгөөн” арга хэмжээний хүрээнд тус суманд 40 хоршоо байгуулагдсанаас сумын газар нутагт үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шалгуур хангасан хоршоод орж ирээгүй зээл олгогдоогүй байна. Мөн өмнөх оны үлдэгдэл 147,582.2 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлт 89,677.9 мянган төгрөг хүлээн авч, урсгал үйл ажиллагаанд 924.8 мянган төгрөгийг зарцуулж 214,404.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

### **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант онд 1 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 98 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>345,842,819.76</b>	<b>351,663,290.76</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>108,582,716.70</b>	<b>214,404,112.70</b>
312	Банканд байгаа бэлэн мөнгө	108,582,716.70	214,404,112.70
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах	108,582,716.70	214,404,112.70
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>237,260,103.06</b>	<b>137,082,178.06</b>
335	Бусад авлага	237,260,103.06	137,082,178.06
3352	Хувь хүмүүсээс авах авлага	237,260,103.06	137,082,178.06
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		<b>177,000.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		
3511	Тусгай зориулалттай материал	0.00	0.00
3513	Эм боох материал		
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>177,000.00</b>
35410	Бичиг хэргийн материал		177,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
3545	Барилгын засварын материал	0.00	0.00
3546	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал		
36	НӨӨЦ БАРАА		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		
39201	Барилга, байгууламж орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
393	<b>Биет бус хөрөнгө</b>		
39301	Программ хангамж		
39302	Хуримтлагдсан элэгдэл		
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>345,842,819.76</b>	<b>351,663,290.76</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>345,842,819.76</b>	<b>351,663,290.76</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	345,842,819.76	351,663,290.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	0.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	<b>345,842,819.76</b>	351,663,290.76
51210	Өмнөх үеийн үр дүн	<b>345,842,819.76</b>	<b>345,842,819.76</b>
51220	Тайлант үеийн үр дүн	-	5,820,471.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>345,842,819.76</b>	<b>351,663,290.76</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,292,350.00	8,404,506.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,292,350.00	8,404,506.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,292,350.00	8,404,506.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,292,350.00	8,404,506.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,292,350.00	8,404,506.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,696,086.00	2,584,035.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,696,086.00	2,584,035.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,696,086.00	2,584,035.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
210201	Тэтгэврийн даатгал		
210502	Хоол, хүнс		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	0.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,696,086.00	2,584,035.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,696,086.00	2,584,035.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,596,264.00	5,820,471.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,596,264.00	5,820,471.00



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	122,184,325.0	108,582,431.0
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	122,184,325.0	108,582,431.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	122,184,325.0	108,582,431.0
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	122,184,325.0	108,582,431.0
120004	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	122,184,325.0	108,582,431.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,184,325.0	108,582,431.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,627,586.0</b>	<b>2,761,035.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,627,586.0</b>	<b>2,761,035.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,627,586.0</b>	<b>2,761,035.0</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,627,586.0</b>	<b>2,761,035.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,627,586.0	2,761,035.0
3	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>120,556,739.0</b>	<b>105,821,396.0</b>
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	(118,043,261.0)	105,821,396.0
22-226	Дотоод эх үүсвэр	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	238,600,000.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	238,600,000.0	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	(238,600,000.0)	-
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(118,043,261.0)</b>	<b>105,821,396.0</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	226,625,977.7	108,582,716.7
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	108,582,716.7	214,404,112.7



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			340,246,555.76	-	340,246,555.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	340,246,555.76	-	340,246,555.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			5,596,264.00		5,596,264.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	345,842,819.76	-	345,842,819.76
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	345,842,819.76	-	345,842,819.76
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			5,820,471.00		5,820,471.00
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	351,663,290.76	-	351,663,290.76



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	200,400,000.00	102,938,960.00	(97,461,040.00)	51.4%
21	Урсгал зардлын дүн	5,000,000.00	2,761,035.00	(2,238,965.00)	55.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	5,000,000.00	2,761,035.00	(2,238,965.00)	55.2%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	2,761,035.00	(2,238,965.00)	55.2%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	195,400,000.00	100,177,925.00		51.3%
230001	Эргэж төлөгдөх зээл	195,400,000.00	100,177,925.00		51.3%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	200,400,000.00	108,582,431.00	(91,817,569.00)	54.2%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,400,000.00	108,582,431.00	(91,817,569.00)	54.2%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,400,000.00	108,582,431.00	91,817,569.00	54.2%
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		108,582,716.70		-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		214,404,112.70		-
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0%
3	Төсвийн байгууллага	-	-	-	-
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-	-	-
	Удирдах ажилтан	-	-	-	-
	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
	Үйлчлэх ажилтан	-	-	-	-



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Хонгор сумын Хоршоо хөгжүүлэх сан нь эрхэм зорилгоо “Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж буй хоршоог дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг төрөөс хоршоо, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх талаар баримталж буй бодлоготой уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, олгох зээлийн болон барьцааны гэрээний загвар, маягтыг батлах, сангаас олгосон зээлийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийг бүрдүүлэн хөтлөх, зохистой харилцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд сангийн дансыг түр хугацаанд хааж, сангийн хөрөнгийг татан төвлөрүүлэх саналыг төсөв, санхүүгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сангийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, энэ журмын 2.7-д заасан санхүүжилтээр сургалт зохион байгуулан ажилладаг байгууллага юм.

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/521 дугаар тогтоол, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Иргэний тухай хууль, Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, Иргэний тухай хууль, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж

эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,820.5 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	108,582.7	214,404.1	105,821.4
Авлага	237,260.1	137,082.2	(100,177.9)
Бараа материал	-	177.0	177.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>345,842.8</b>	<b>351,663.3</b>	<b>5,820.5</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	345,842.8	351,663.3	5,820.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>345,842.8</b>	<b>351,663.3</b>	<b>5,820.5</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 214,404.1 мянган төгрөгт хүрч 105,821.4 мянган төгрөгөөр өссөн нь зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс 108,582.4 мянган төгрөгийн орлого орж үйл ажиллагааны зардал 2,761.0 мянган төгрөгөөр зарцуулснаас шалтгаалсан байна.

Зээлийн авлага дансны үлдэгдэл 237,260.1 мянган төгрөг болж 100,177.9 мянган төгрөгөөр буурсан нь зээлийн хүүгийн авлага 8,404.5 мянган төгрөг нэмэгдэж, 108,582.4 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 351,663.3 мянган төгрөг болж 5,820.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 195,400.0 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг хэвээр баталсан байна.

Төсвийн дунд хугацааны хүрээний мэдэгдэл нь тайлант хугацааны төсвийн төсөлтэй уялдаж, Төсвийн тухай хуульд заасан төсвийн шаардлагад нийцсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр тайлант оны батлагдсан зээл нийт 195,400.0 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр тайлант онд зээлийн эргэн төлөлтөөс 100,177.6 мянган төгрөг, зээлийн хүү 8,404.8 мянган төгрөг буюу нийт 108,582.4 мянгна төгрөг мөнгөн орлого орноос үйл ажиллагааны зардалд 2,761.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 2,761.0 мянган төгрөг буюу 55.2 хувьтай байгаа нь тайлант онд зээл авах хоршоодийн зээлийн шалгуур хангаагүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>70106-Хөтөлбөр Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>200,400.00</b>	<b>102,938.96</b>	<b>(97,461.04)</b>	<b>51.4%</b>
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	5,000.00	2,761.04	(2,238.97)	55.2%
1.2	83111- Сум хөгжүүлэх	195,400.00	100,177.93	(95,222.08)	51.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант онд тус байгууллага нь 210801-Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2,761.0 мянган төгрөгийг зарцуулж, Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/54 тоот албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 345,842.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,458.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан, ажиллаж байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 7,354.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	7,354.4	1	7,354.4	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>7,354.4</b>	<b>1</b>	<b>7,354.4</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

##### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

##### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

##### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-